БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Бөөнцагаан-Орог нуурын сав газрын захиргааны 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

**Аудитын код:** БНА-2019/82/СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn
Баянхонгор сум 2019 он


Тэргүүлэх аудитор: Б.Мөнхбат
Утас: 99007576 Цахим хаяг: munkhbatb@audit.gov.mn
Аудитын менежер: Д.Цэцэгмаа
Утас: 88089024 Цахим хаяг: tsetsegmaadam@audit.gov.mn
Аудитор: П.Амаржаргал
Утас: 88106992 Цахим хаяг: amaraa_802002@yahoo.com


Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

# Товчилсон үгийн жагсаалт

| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт |
| АДБОУС | Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт |
| АОУС | Аудитын олон улсын стандарт |

## Агуулга


1 Аудитын гэрчилгээ ..... 3

2 Аудитын тайлан ..... 5

2.1 Оршил ..... 5

2.2 Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага ..... 5

2.3 Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт ..... 6

2.4 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин ..... 6

2.5 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ ..... 7

2.6 Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал ..... 8

2.7 Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар ..... 8

2.8 Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн ..... 9

2.8.1 Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал ..... 9

2.9 Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал ..... 10

2.10 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга ..... 10

2.11 Шилэн дансны мэдээлэл ..... 10

2.12 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга ..... 10

2.13 Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл ..... 11

3 Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл ..... 11

3.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан ..... 11

3.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан ..... 12

3.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан ..... 13

3.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан ..... 15

3.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан ..... 15

# 1 Аудитын гэрчилгээ

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
64101 Номгон, Баянхонгор сум
Утас, факс 70-44-25-84
E-mail; bayankhongor@audit.gov.mn

2019.02.18 № 2/33

танай ______________ -ны №______________ -т

БАЯНХОНГОР АЙМГИЙН БӨӨН ЦАГААН-ОРОГ НУУРЫН САВ ГАЗРЫН ДАРГА Г.ЖАВХЛАН ТАНАА

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-т заасны дагуу Баянхонгор аймгийн Бөөнцагаан-Орог нуурын сав газрын 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

**Зөрчилгүй санал дүгнэлт**

Баянхонгор аймгийн Бөөнцагаан-Орог нуурын сав газрын 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

**Санал дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Баянхонгор аймгийн Бөөнцагаан-Орог нуурын сав газрын 2018 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл,санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэлийн хөтлөлт, програм хангамж, дотоод

D:\Amaraa\amaraa\2019\boon tsagaan\tailagnal\АМ-Бөөнцагаан-Орог нуур Аудитын гэрчилгээ.docx

2519032

хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

**Үүрэг хариуцлага**

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-т заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудитын хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Б.МӨНХБАТ

D:\Amaraa\amaraa\2019\boon tsagaan\tailagnal\АМ-Бөөнцагаан-Орог нуур Аудитын гэрчилгээ.docx

# 2.АУДИТЫН ТАЙЛАН

## 1.1 ОРШИЛ

Бөөнцагаан-Орог нуурын сав газрын захиргааны 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг Бөөнцагаан-Орог нуурын сав газрын захиргааны дарга Г.Жавхлан-д танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Дараагийн заалтад аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг батлагдсан ангилал, үзүүлэлтээр бэлтгэж оруулав.

## 1.2 Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Бөөнцагаан-Орог нуурын сав газрын захиргааны 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бөөнцагаан-Орог нуурын сав газрын захиргаа нь 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2019 оны 01 дүгээр сарын 29-ний 2019 оны 01 дүгээр сарын 29–ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2019 оны 02 дугаар сарын 18-ны өдөр эцэслэн баталгаажуулж, Төсвийн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Баянхонгор аймаг дахь төрийн аудитын газрын аудитор П.Амаржаргал хариуцаж хэрэгжүүлэв.

Бөөнцагаан-Орог нуурын сав газрын захиргаа 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Баянхонгор аймаг дахь төрийн аудитын газарт 2019 оны 01 дугаар сарын 25-ны өдрийн 7/15 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

## 1.3 Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитын үйл явц, үр дүнг АДБОУС, АОУС-ын дагуу шат шатны чанарын хяналт хийж баталгаажуулсан болно.

Аудитыг дээрх бодлого, арга зүйд нийцүүлэн төлөвлөлтийн шатанд баталсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

## 1.4 БАЙГУУЛЛАГЫН ЗОРИЛГО, ҮЙЛ АЖИЛЛАГАА, ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ОРЧИН

Бид аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу байгууллагын үйл ажиллагаа, түүний гадаад дотоод орчны талаар шаардлагатай хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

Бөөнцагаан-Орог нуурын сав газрын захиргааны талаарх ерөнхий мэдээллийг аудитыг төлөвлөх үе шатанд шинэчлэн баримтжуулж, А101 маягтаар баталгаажуулсан болно.

Эрхэм зорилго:

“ Усны нөөцийг хомосдол бохирдлоос хамгаалж, зүй зохистой ашиглах, орон нутгийн болон салбар дундын зохицуулалтыг хангахад оршино” гэж үйл ажиллагааны чиглэл зорилтоо тодорхойлон ажиллажээ.

Бөөнцагаан-Орог нуурын сав газрын захиргааны үндсэн болон үндсэн бус үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд судалж, баримтжуулсан.

Бөөнцагаан-Орог нуурын сав газрын захиргааны удирдлага төсвийн шууд захирагчийн хувьд дараах хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна.

Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Монгол Улсын 2018 оны Төсвийн тухай хууль
- Зөрчлийн тухай хууль
- Усны тухай хууль
- Байгалийн нөөц ашигласаны төлбөрийн тухай хууль
- Байгаль орчны багц хуулиуд

Тайлант хугацаанд дээрх бодлого, журамд томоохон шинэчлэлт, өөрчлөлт гараагүй болно.

### 1.5 НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН БОДЛОГО, ҮЙЛ АЖИЛЛАГАА БОЛОН ДОТООД ХЯНАЛТТАЙ ХОЛБООТОЙ ХҮЧИН ЗҮЙЛСИЙН ҮНЭЛГЭЭ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Тус газрын одоо мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцтэй байгаа эсэхийг судалж үзэхэд шинээр батлагдсан бодлого, журамд нийцсэн байна.

Бөөнцагаан-Орог нуурын сав газрын захиргааны санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн төвөгтэй байдлыг үнэлэхэд 41 буюу мэдээллийн технологийн мэргэжилтнийг аудитад татан оролцуулах шаардлагагүй гэж үзлээ.

Бөөнцагаан-Орог нуурын сав газрын захиргаа санхүүгийн тайланг бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн “Санхүүгийн тооцоолох групп" ХХК-ийн "Acolous” программ хангамж ашигладаг байна.

Бөөнцагаан-Орог нуурын сав газрын захиргааны дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд “Дунд” гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт Үр нөлөөтэй гэж үзлээ.

## 1.6 Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитын явцад Бөөнцагаан-Орог нуурын сав газрын захиргааны бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 6 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 2 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

Аудитын чиглэл тус бүрд хамаарах илрүүлсэн эрсдэлийн жагсаалт, түүний үнэлгээг Б301 маягтаар, эрсдэлтэй асуудлыг сорих аудитын горим, сорил, түүнийг баримтжуулах, нотлох зүйлс цуглуулах арга зүйг Б401, Б402 маягтаар тус тус баримтжуулав.

## 1.7 Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгов.

Санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг материаллаг байдлын суурь үзүүлэлтээр сонгосон нь улсын төсвөөс санхүүждэг төсөвт байгууллагын хувьд байгууллагын нийт зардлыг суурь үзүүлэлт болгон сонгох нь зохимжтой гэж үзсэнтэй холбоотой юм.

Бөөнцагаан-Орог нуурын сав газрын захиргаа 2018 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 169,4 сая төгрөг бөгөөд түүний 2 хувь болох 3,3 сая төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлын түвшинг Б201, аудитыг гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшинг В401 маягтаар тус тус баримтжуулан баталгаажуулав.

## 1.8 АУДИТЫН ЯВЦАД ХЭРЭГЖҮҮЛСЭН ГОРИМ СОРИЛ, ТҮҮНИЙ ҮР ДҮН

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 5 чиглэлээр аудитын 7 горим сорил гүйцэтгэж, үнэлэхэд 1 асуудлын алдаа, зөрчилтэйд тооцож, 6 асуудлыг алдаа, зөрчилд тооцохгүй гэж шийдвэрлэснээс аудитын явцад санхүүгийн тайланд залруулга хийгдээгүй.

Аудитын явцад илрүүлсэн залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг В501 маягтаар нэгтгэж, баримтжуулсан бөгөөд байгууллагын удирдлага болон холбогдох албан тушаалтнуудад танилцуулж, баталгаажуулсан.

Дээрх залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг дараах байдлаар ангилав.

(Мянган төгрөгөөр)

| № | Шийдэл | Тоо | Дүн | Тайлбар |
|---|---|---|---|---|
| 1 | Төлбөрийн акт тогтоосон | 1 | 760,9 | |
| | Дүн | 1 | 760,9 | |

### 1.8.1 Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал

Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчилтэй асуудлаас алдаа, зөрчилтэй асуудлын дэлгэрэнгүйг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв. Үүнд:

1. Бөөнцагаан-Орог нуурын сав газрын захиргааны даргын тушаалаар албан хаагчдад 760.9 мянган төгрөгийн түлээ нүүрсний хөнгөлөлт бодож олгосныг төлбөрийн акт тогтоосон.

### 1.9 Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Байхгүй

### 1.10 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн шууд захирагч нь батлагдсан төсөв, түүний гүйцэтгэлийг зохих журмын дагуу зохион байгуулсан, үнэн зөв, тайлагнасан эсэхэд үнэлэлт өгөхийг зорьдог.

Бөөнцагаан-Орог нуурын сав газрын захиргаа чиг үүргээ хэрэгжүүлэхтэй нь холбоотой хөтөлбөр, арга хэмжээнд зориулан 2018 онд 545,9 сая төгрөгийн төсөв батлагджээ. Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг энэ тайлангийн 4.5-д дэлгэрэнгүй харуулав.

Төсвийн зардлын нийт гүйцэтгэл 133,9 сая төгрөг буюу 98 хувьтай байгаа нь 2018 онд 136,7 сая төгрөгийн санхүүжилт авч урсгалд үйл ажиллагааны зардал зарцуулан 2,7 сая төгрөг хэмнэгдсэнтэй холбоотой байна.

### 1.11 Шилэн дансны мэдээлэл

Бөөнцагаан-Орог нуурын сав газрын захиргаа Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй.

Тус байгууллагын Шилэн дансны хуулиар хүлээсэн үүргийн биелэлтийг төлөвлөсөн хэмжээнд хянаж, баримтжуулсан болно.

### 1.12 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Өмнөх санхүүгийн тайланд зөвлөмж өгөгдөөгүй байна.

## 1.13 САНАЛ ДҮГНЭЛТИЙН ХЭЛБЭР, ҮНДЭСЛЭЛ

Бид Бөөнцагаан-Орог нуурын сав газрын захиргааны 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Бөөнцагаан-Орог нуурын сав газрын захиргааны 2018 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдээ холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 3.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

## 1.14 АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| 1 | ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН | 6,376,500.00 | 6,830,253.00 |
| 33 | АВЛАГА | 00.00 | 12,255.00 |
| 335 | Бусад авлага | 00.00 | 12,255.00 |
| 3351 | Байгууллагаас авах авлага | 00.00 | 12,255.00 |
| 35 | БАРАА МАТЕРИАЛ | 6,376,500.00 | 6,817,998.00 |
| 351 | Түүхий эд материал | 3,000,000.00 | 3,000,000.00 |
| 35110 | Тусгай зориулалттай материал | 3,000,000.00 | 3,000,000.00 |
| 354 | Хангамжийн материал | 3,376,500.00 | 3,817,998.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 2,353,000.00 | 3,229,498.00 |
| 35430 | Сэлбэг хэрэгсэл | 983,500.00 | 503,500.00 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 40,000.00 | 85,000.00 |
| 2 | ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН | 34,604,333.06 | 32,922,547.88 |
| 39 | ҮНДСЭН ХӨРӨНГӨ | 34,604,333.06 | 32,922,547.88 |
| 392 | Биет хөрөнгө | 34,572,249.88 | 32,922,547.88 |
| 39203 | Авто тээврийн хэрэгсэл | 31,896,000.00 | 31,896,000.00 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | -18,269,124.68 | -23,856,332.99 |
| 39205 | Машин, тоног төхөөрөмж | 33,182,866.00 | 44,361,866.00 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | -20,436,257.41 | -26,430,962.62 |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 12,467,884.39 | 12,467,884.39 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | -4,269,118.42 | -5,515,906.90 |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 195,000.00 | 195,000.00 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | -195,000.00 | -195,000.00 |
| 393 | Биет бус хөрөнгө | 32,083.18 | 00.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 39301 | Програм хангамж | 770,000.00 | 770,000.00 |
| 39302 | Хасагдуулга | -737,916.82 | -770,000.00 |
| 3 | НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН | 40,980,833.06 | 39,752,800.88 |
| 4 | НИЙТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН | 00.00 | 80,900.00 |
| 41 | БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР | 00.00 | 80,900.00 |
| 413 | Өглөг | 00.00 | 80,900.00 |
| 4136 | Бусад өглөг | 00.00 | 80,900.00 |
| 41362 | Хувь хүмүст төлөх өглөг | 00.00 | 80,900.00 |
| 5 | ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН | 40,980,833.06 | 39,671,900.88 |
| 51 | Засгийн газрын хувь оролцоо | 40,980,833.06 | 39,671,900.88 |
| 512 | Хуримтлагдсан үр дүн | 40,980,833.06 | 39,671,900.88 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 40,980,833.06 | 40,980,833.06 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | -1,308,932.18 |
| 6 | ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН | 40,980,833.06 | 39,752,800.88 |

## 1.15 АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| 1 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I) | 146,006,916.00 | 168,158,450.00 |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 7,833,816.00 | 980,000.00 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 00.00 | 980,000.00 |
| 120004 | Төсөвт байгууллагын өөрийн орлого | 00.00 | 980,000.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 00.00 | 980,000.00 |
| 121 | Хөрөнгийн орлого | 7,833,816.00 | 00.00 |
| 121001 | Төрийн болон орон нутгийн өмчид бүртгэлтэй хөрөнгө борлуулсны орлого | 7,833,816.00 | 00.00 |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 138,173,100.00 | 167,178,450.00 |
| 1310 | Улсын төвлөрсөн төсвөөс | 135,683,100.00 | 136,682,300.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 135,683,100.00 | 136,682,300.00 |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 2,490,000.00 | 30,496,150.00 |
| 131103 | ЗГНХ, Засаг даргын нөөц хөрөнгө түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөнөөс | 00.00 | 30,496,150.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 2,490,000.00 | 00.00 |
| 2 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН (II) | 146,445,122.09 | 169,467,382.18 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 142,793,853.09 | 165,713,418.18 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 142,793,853.09 | 165,713,418.18 |
| 2101 | Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил | 100,046,486.00 | 100,428,874.00 |
| 210101 | Цалин | 100,046,486.00 | 100,428,874.00 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 10,872,320.00 | 12,021,397.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгалын шимтгэл | 10,872,320.00 | 12,021,397.00 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 8,541,000.00 | 8,940,000.00 |
| 210304 | Байрны түрээс | 8,541,000.00 | 8,940,000.00 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 6,633,225.00 | 6,422,860.00 |
| 210401 | Бичиг хэргийн материал | 1,417,650.00 | 2,012,600.00 |
| 210402 | Тээвэр, шатахууны зардал | 3,905,750.00 | 3,117,200.00 |
| 210403 | Шуудан холбоо интернетийн төлбөр | 818,425.00 | 893,060.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210406 | Бага үнэ түргэн элэгдэл зүйлс | 491,400.00 | 400,000.00 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 680,900.00 | 3,669,902.00 |
| 210601 | Багаж хэрэгсэл | 00.00 | 797,002.00 |
| 210604 | Урсгал засвар | 680,900.00 | 2,872,900.00 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 2,582,000.00 | 2,574,500.00 |
| 210702 | Дотоод томилолтын зардал | 2,582,000.00 | 2,574,500.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамж | 522,700.00 | 18,295,100.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 00.00 | 17,832,000.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт зэрэглэл тогтоох зардал | 297,000.00 | 200,000.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээний төлбөр | 118,800.00 | 118,800.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 73,900.00 | 111,300.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношилгоо | 33,000.00 | 33,000.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 12,915,222.09 | 13,360,785.18 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 00.00 | 500,000.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 12,915,222.09 | 12,860,785.18 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 3,651,269.00 | 3,753,964.00 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 3,000,000.00 | 00.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж шагнал урамшуулал | 3,000,000.00 | 00.00 |
| 2133 | Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг | 651,269.00 | 3,753,964.00 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 651,269.00 | 3,753,964.00 |
| 3 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III=I-II) | -438,206.09 | -1,308,932.18 |
| 5 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН (V) | 2,355,973.37 | 00.00 |
| 225001 | Үндсэн хөрөнгө худалдсаны гарз | 2,355,973.37 | 00.00 |
| 6 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (VI=IV-V) | -2,355,973.37 | 00.00 |
| 7 | НИЙТ ҮР ДҮН (VII=III+VI) | -2,794,179.46 | -1,308,932.18 |

## 1.16 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| 1 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I) | 138,173,100.00 | 168,239,350.00 |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 00.00 | 1,060,900.00 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 00.00 | 1,060,900.00 |
| 120004 | Төсөвт байгууллагын өөрийн орлого | 00.00 | 1,060,900.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 00.00 | 1,060,900.00 |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 138,173,100.00 | 167,178,450.00 |
| 1310 | Улсын төвлөрсөн төсвөөс | 135,683,100.00 | 136,682,300.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 135,683,100.00 | 136,682,300.00 |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 2,490,000.00 | 30,496,150.00 |
| 131103 | ЗГНХ, ЗДНХөрөнгө түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөнөөс | 00.00 | 30,496,150.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 2,490,000.00 | 00.00 |
| 2 | НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (II) | 138,173,100.00 | 168,239,350.00 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 138,173,100.00 | 168,239,350.00 |
| 210 | БАРАА АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 134,521,831.00 | 164,485,386.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 2101 | Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил | 99,921,939.00 | 100,138,171.00 |
| 210101 | Үндсэн цалин | 84,214,539.00 | 67,353,730.00 |
| 210102 | Нэмэгдэл | 9,021,000.00 | 21,886,573.00 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 6,686,400.00 | 10,897,868.00 |
| 2102 | Ажил олгочоос нийгтийн даатгалд төлөх шимтгэл | 10,985,567.00 | 12,312,100.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгалын шимтгэл | 10,985,567.00 | 11,700,652.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгалын шимтгэл | 00.00 | 152,860.00 |
| 210203 | ҮОМШ өвчний даатгалын шимтгэл | 00.00 | 122,288.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгалын шимтгэл | 00.00 | 30,572.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгалын хураамж | 00.00 | 305,728.00 |
| 2103 | Байр ашиглалтай холбоотой тогтмол зардал | 8,946,000.00 | 8,940,000.00 |
| 210304 | Байрны түрээс | 8,946,000.00 | 8,940,000.00 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 6,517,825.00 | 6,517,815.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 965,150.00 | 1,360,400.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 3,905,750.00 | 3,117,200.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 865,925.00 | 905,315.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 781,000.00 | 1,134,900.00 |
| 2105 | Нормативт зардал | 624,500.00 | 624,500.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 624,500.00 | 624,500.00 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 2,272,800.00 | 2,273,000.00 |
| 210601 | Багаж техник хэрэгсэл | 410,500.00 | 638,900.00 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллийн хэрэгсэл | 166,000.00 | 356,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 1,696,300.00 | 1,278,100.00 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 2,582,000.00 | 2,574,500.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 2,582,000.00 | 2,574,500.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 2,671,200.00 | 28,936,600.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил, үйлчилгээний төлбөр хураамж | 2,000,000.00 | 28,325,000.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 297,000.00 | 200,000.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 118,800.00 | 118,800.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 73,900.00 | 111,300.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 33,000.00 | 33,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 148,500.00 | 148,500.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 00.00 | 2,168,700.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 00.00 | 2,168,700.00 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 3,651,269.00 | 3,753,964.00 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 3,000,000.00 | 00.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж шагнал урамшуулал | 3,000,000.00 | 00.00 |
| 2133 | Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг | 651,269.00 | 3,753,964.00 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 651,269.00 | 3,753,964.00 |

## 1.17 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Бусад | Засгийн газрын хувь оролцооний нийт дүн |
|---|---|---|---|---|---|---|
| C01 | 2017 оны 1-р сарын 1-ээрх үлдэгдэл | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| C02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| C03 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| C04 | Дахин үнэлгээний нэмэгдэл, хэрэгжсэн дүн | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| C05 | Хөрөнгө оруулалтын дахин үнэлгээний гарз | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| C06 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз гарз | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| C07 | Тайлант үеийн үр дүн /Цэвэр ашиг алдагдал/ | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| C08 | 2015 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| D01 | 2017 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл | 00.00 | 00.00 | 40,980,833.06 | 00.00 | 40,980,833.06 |
| D02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| D03 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 00.00 | 00.00 | 40,980,833.06 | 00.00 | 40,980,833.06 |
| D04 | Дахин үнэлгээний нэмэгдэл, хэрэгжсэн дүн | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| D05 | Хөрөнгө оруулалтын дахин үнэлгээний гарз | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| D06 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз гарз | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| D08 | Тайлант үеийн үр дүн /Цэвэр ашиг алдагдал/ | 00.00 | 00.00 | -1,308,932.18 | 00.00 | -1,308,932.18 |
| D09 | 2018 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл | 00.00 | 00.00 | 39,671,900.88 | 00.00 | 39,671,900.88 |

## 1.18. Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Өмнөх оны | | Тайлант оны | |
|---|---|---|---|---|---|
| | | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл |
| 2 | I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 135,683,100.00 | 135,521,831.00 | 136,682,300.00 | 133,991,686.00 |
| 21 | УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН | 135,683,100.00 | 135,521,831.00 | 136,682,300.00 | 133,991,686.00 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 210 | Бараа, үйлчилгээний зардал | 132,683,100.00 | 132,521,831.00 | 136,682,300.00 | 133,991,686.00 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 99,922,000.00 | 99,921,939.00 | 102,600,500.00 | 100,138,171.00 |
| 210101 | Үндсэн цалин | 84,214,600.00 | 84,214,539.00 | 72,942,600.00 | 67,353,730.00 |
| 210102 | Нэмэгдэл | 9,021,000.00 | 9,021,000.00 | 22,971,500.00 | 21,886,573.00 |
| 210103 | Унаа, болон бусад нөхөн олговор | 6,686,400.00 | 6,686,400.00 | 6,686,400.00 | 10,897,868.00 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 10,991,400.00 | 10,985,567.00 | 12,312,100.00 | 12,312,100.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 10,991,400.00 | 10,985,567.00 | 8,208,100.00 | 10,024,534.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 00.00 | 00.00 | 1,026,000.00 | 936,400.00 |
| 210203 | ҮОМШӨ ний даатгал | 00.00 | 00.00 | 820,800.00 | 748,800.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 00.00 | 00.00 | 205,200.00 | 187,900.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 00.00 | 00.00 | 2,052,000.00 | 414,466.00 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 8,949,300.00 | 8,946,000.00 | 8,949,300.00 | 8,940,000.00 |
| 210304 | Байрны түрээс | 8,949,300.00 | 8,946,000.00 | 8,949,300.00 | 8,940,000.00 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 6,517,900.00 | 6,517,900.00 | 6,517,900.00 | 6,517,815.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 1,360,400.00 | 965,150.00 | 1,360,400.00 | 1,360,400.00 |
| 210402 | Тээвэр (шатахуун) | 3,117,200.00 | 3,905,750.00 | 3,117,200.00 | 3,117,200.00 |
| 210403 | Шуудан холбоо, интернэтийн төлбөр | 887,500.00 | 865,925.00 | 887,500.00 | 905,315.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, аж ахуйн эд зүйлс | 1,152,800.00 | 781,000.00 | 1,152,800.00 | 1,134,900.00 |
| 2105 | Нормативт зардал | 624,500.00 | 624,500.00 | 624,500.00 | 624,500.00 |
| 210503 | Нормын хувцас зөөлөн эдлэл | 624,500.00 | 624,500.00 | 624,500.00 | 624,500.00 |
| 2106 | Эд хогшил худалдан авах | 2,273,400.00 | 2,272,800.00 | 2,273,400.00 | 2,273,000.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 638,900.00 | 410,500.00 | 638,900.00 | 638,900.00 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэгсэл | 356,400.00 | 166,000.00 | 356,400.00 | 356,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 1,278,100.00 | 1,696,300.00 | 1,278,100.00 | 1,278,100.00 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 2,582,900.00 | 2,582,000.00 | 2,582,900.00 | 2,574,500.00 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 210702 | Дотоод албан томилолт | 2,582,900.00 | 2,582,000.00 | 2,582,900.00 | 2,574,500.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр | 821,700.00 | 671,200.00 | 821,700.00 | 611,600.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт зэрэглэл тогтоох зардал | 297,000.00 | 297,000.00 | 297,000.00 | 200,000.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 118,800.00 | 118,800.00 | 118,800.00 | 118,800.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 198,000.00 | 73,900.00 | 198,000.00 | 111,300.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношилгоо | 59,400.00 | 33,000.00 | 59,400.00 | 33,000.00 |
| 210806 | Мэдээллийн технологийн зардал | 148,500.00 | 148,500.00 | 148,500.00 | 148,500.00 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 3,000,000.00 | 3,000,000.00 | 00.00 | 00.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж урамшуулал | 3,000,000.00 | 3,000,000.00 | 00.00 | 00.00 |
| | ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР | 135,683,100.00 | 135,521,831.00 | 136,682,300.00 | 133,991,686.00 |
| 1310 | УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ | 135,683,100.00 | 135,521,831.00 | 136,682,300.00 | 133,991,686.00 |
| 131001 | Улсын төсвөөс санхүүжих | 135,683,100.00 | 135,521,831.00 | 136,682,300.00 | 133,991,686.00 |
| 62 | АЖИЛЛАГСДЫН ТОО | 00.00 | 00.00 | 10.00 | 10.00 |
| 620001 | Удирдах ажилтан | 00.00 | 00.00 | 01.00 | 01.00 |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 00.00 | 00.00 | 08.00 | 08.00 |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 00.00 | 00.00 | 01.00 | 01.00 |